

МОНГОЛ ГАЗАР УСНЫ НЭРИЙГ ЗӨВ БИЧИХ АСУУДАЛД

Э.Пүрэвжав

“Монгол хэлний үгийн сан судлал” хэмээх хамтын судалгааны бүтээлд “Монгол газар нутгийн оноосон нэр нь эрт эдүгээг холбосон соёлын гүүр буюу үгээр бүтээсэн түүхийн хөшөө дурсгал мөн”¹ хэмээн тодорхойлсон нь буй.

Аливаа хэлний оноосон нэр бол тухайн хэлнийхээ үгийн сангийн бүрэлдэхүүний чухал ай мөн. Газар усны нэр нь эртний түүхэн уламжлал, хүн төрөлхтөний аж төрөл, амьдрал ахуйн өвөрмөц онцлогтой маш их холбоотой үзэгдэл юм. Газар усны нэр нь хэдэн мянган жилийн тэртээ өмнөөс түмний хэрэглээ болсон нь магад билээ.

Монгол туургатны дотор нутаглаж байгаа газар орноо туйлын сайн мэддэг өвгөн буурал газарч өвгөд хөгшид олон бий. Ийм учраас л

*Газрын толгой олон
Газарчийн толгой ганц,
Хойшоо харвал газарч болдог
Хойтохоо санавал тусч болдог*

гэх буюу

*Эргэж харвал газарч болдог
Ээлжээ бодвол тусч болдог*

хэмээсэн монгол зүйр цэцэн үг байдгийг дурдалтай.

Монгол газар усны нэрийн гарал үүслийг судлан тогтооход эх түүх, хэл бичиг, утга соёл, зан заншил, шашин шүтлэг, газар зүй тэргүүтэн олон салбар шинжлэх ухаан холбогдоно. Монгол газар усны нэрийн гарал үүслийг зөв тогтоохдоо нийгэм түүхийн үйл явдлын мөрөөр хөөн тодруулж, үндэсний хэл, эх түүх, шашин шүтлэг, газар зүй, угсаатан зүй зэрэг олон салбар шинжлэх ухааны баримт хэрэглэгдэхүүнд түшиглэх ёстой.

Монгол газар усны нэрийн гарал үүслийг зөв тогтооход үгийн хэлбэр, авианы бүрхүүл бүтцийн талаас судлах нь чухал ач холбогдолтой боловч зарим газрын нэрсийн авианы бүрхүүлийн хуурмаг хэлбэрт төөрөлдөх явдал гардгийг анхаарч үзвээс зохилтой. Тухайлбал: “Өгий нуур” (Архангай) гэдэг нэрийг “Угэй нуур” [“не озера”, “безлюдная земля”] гэсэн утгатай хэмээн зарим эрдэмтэн үздэг. Зарим судлаач усны цэнгэг, өнгө үзэмжээр нэрлэсэн утгатай нэрсэд багтааж үзсэн нь бий. Энэ нэрийг нягтлан үзвэл, үүнээс өөрөөр тайлбарлаж болох юм. Энэхүү “Өхүй” буюу “Өгий” гэсэн нэр нь эмэгтэй хүнийг дуудах хүндэтгэлийн үг буюу “эгч” гэсэн утгатай үг ажээ. Иймд “Эгч нуур” буюу “Хатан нуур”² хэмээн ойлгож болно.

“Монгол газар усны нэрийг зөв бичих” гэсэн ойлголтыг ерөнхий утгаар нь авч үзвэл дэлхий дахины бүхий л газар ус, хот балгадын нэрийг монгол хэлээр зөв тэмдэглэх асуудал,

¹ Монгол хэлний үгийн сан судлал (“Монгол улсын Шинжлэх ухаан” хэмээх 108 боть цувралын XII боть). -Улаанбаатар., 2009. х.92

² О.Сүхбаатар. Монголын газар усны нэрийн домог (Mongolian Legends of the Land) [редактор Х.Сампилдэндэв]. -Улаанбаатар., 2001. х.44

Э.Пүрэвжав

ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн

Purvee_9@yahoo.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

явцуу утгаар хэлбэл Монголын газар усны нэрийг зөв бичих хэмээсэн өргөн утга агуулгатай болно. Монгол газар зүйн оноосон нэрийг хэрхэн бичих тухай асуудал бол зөвхөн газар зүйн мэргэжлээр барахгүй, хэл бичгийн ухааны мэдэгдэхүүн шаардагдах нарийн бэрхтэй ажил юм. Газар зүйн оноосон нэрийг зөв бичихдээ орчин цагийн монгол хэлний дуудлагыг³ гол болгон баримтлах учиртай. Монгол оноосон нэрийг монгол хэлний нийлэмж үг, нийлмэл үг бичих дүрмээр бичиж заншжээ.

Монголын их бичгийн хүмүүн Онход овогт Сангажавын Жамьян (1864-1930) “Анхан сурах хөвгүүдийн оюуныг нээх Тодорхой толь хэмээгдэх оршив” (Feeheeeea sogeeO KibeKoa oa foYoа I NeheheK DodoreeeI DoII kemehdeK forosibel) гэдэг бүтээлдээ монгол хэлний үсгийн дуудлага, хэлэгдэх гол онцлогт түшиглэн авиаг таван махбодоор ангилсан⁴ нь тун сонин болжээ. Эх зохиолоос нь ишлэвэл: “Үсгийн махбод хэмээвээс, “a fe, e f, o fo, u fo, ng fit” хийгээд “ya Ge, qa He” төрлөөр хамт 19 үсгийг дуудахуйд хоолойн орноос төрөхийн тул **огторгуй** махбодтой; “a fe” хийгээд “ja Je, ça Ce, ša Ze, ya ye, ža je” төрлөөрөө хамт 36 үсэг хэлний үзүүр, шүд, тагнайгаас гарах тул **хий** махбодтой; “ra re” төрлөөр 7 үсэг орой хөдөлж гарах тул **гал** махбодтой; “da de, ta De, na Ne, la le, sa se” төрлөөр 35 үсэг хэлний үзүүр, шүднээс гарах тул **шороо** махбодтой; “ö foi, ü foi, wa we, we we” хийгээд “ma me, ba be, fa qe” төрлөөр хамт 25 үсэг уруул хумбихын орноос гарах тул **усан** махбодтой хэмээсэн ба үсгийн махбодыг ялгаж танилцуулсны тус хэрэг нь юун буй хэмээвээс, нэрийн тэргүүн үсэг “хаан түшмэл” мэт хийгээд “ноён боол” мэт ба “лам шавь” мэт хийгээд “эр эм” мэт ба “эцэг хөвгүүн” мэт хийгээд “хатан шивэгчин” мэтүүдийн нэрийн тэргүүн хоёр үсгийг нөхөр, дайсныг тоолж, “түшмэл, эх” бөгөөд “ноён хөвгүүн” болбоос, “эрхэм сайн” хийгээд, түүнчлэн “лам шавь” ба “эр эм”-д бээр түүн лүгээ адил эцгийн нэрийн тэргүүн үсэг хийгээд хөвгүүний нэрийн тэргүүн үсэг хөвгүүн болбоос сайн болой. Түүнчлэн “эх охин”-д бээр адил болой. Бас гэргийтэн хүн аль газарт буух буюу гэр барих болбоос, тэр газрын нэрийн тэргүүн үсэг, өөрийн нэрийн тэргүүн үсэг хоёрын нөхөр дайсныг тоолж, газрын нэрийн тэргүүнээ үсэг эх болбоос, их зохистой хэмээн номложээ”⁵ гэж оноосон нэрсийн арга, билгийн зохицлын талаар ихээхэн сонирхолтой баримт өгүүлснийг нь улам лавшруулан судалбал зохино. Энд өгүүлж буй “Бас гэргийтэн хүн аль газарт буух буюу гэр барих болбоос, тэр газрын нэрийн тэргүүн үсэг, өөрийн нэрийн тэргүүн үсэг хоёрын нөхөр дайсныг тоолж, газрын нэрийн тэргүүнээ үсэг эх болбоос, их зохистой хэмээн номложээ” гэсэн хэсэг нь нэн сонирхолтой байгаа агаад “газрын нэрийн тэргүүнээ үсэг эх болох”-ыг онцгойлон дурдсан нь бүр ч их анхаарал татаж байна. Энэ бол нүүдэлчин монголчуудын нүүж суух газар орноо сонгон авах нэгэн эгэл энгийн шалгуур үзүүлэлт байсан бололтой.

Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн гишүүдийн 1924 оны II сарын 11-ний өдрийн хурлаар “Нэр томьёоны комисс байгуулах” асуудлыг тусгайлан хэлэлцэж, тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор Ж.Цэвээн (1880-1942)-ээр даргалуулан, албан ёсны комиссыг арван салбартайгаар зохион байгуулжээ. Байгалийн шинжлэх ухааны шинээр байгуулагдсан нэр томьёоны гурван салбар комисс 1924 оны II сарын 28-ны өдөр хамтран хуралдаж, дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

1. Монгол хэлнээ орчуулж болохоор бол монгол үсгээр орчуулж бичих
2. Хэрэв тогтсон монгол нэр байхгүй, орчуулах боломжгүй бөгөөд монгол хэлний үндэснээс шинэ нэр зохиож болох ахул тийнхүү монгол шинэ нэрээр нэрлэх
3. Орчуулах, монгол нэр өгөх боломжгүй бол анх гарсан нэрээр нь хэрэглэх
4. Түмэн бодис, чулуу ургамал, амьтан гурван аймаг ба физик, химийн ангид монгол хэлэнд тохирох нэргүй бол турк, манж, унгар зэрэг хэлэнд хэрэглэж буй нэрээс

³ А.Лувсандэндэв. Газар зүйн оноосон нэр бичих дүрэм. –“А.Лувсандэндэв. Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь”. -Улаанбаатар., 2002. х.324

⁴ Э.Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлалд О.Жамьян гүнгийн оруулсан хувь нэмэр. –“Монгол хэл шинжлэл”, IX (XXXI) боть, III дэвтэр. -Улаанбаатар., 2006. х.29

⁵ О.Жамьян. Анхан сурах хөвгүүдийн оюуныг нээх Тодорхой толь хэмээгдэх оршив. –“Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг”. -Хөххот., 1959.х.174

монгол хэлэнд илүү тохирох, илүү нийцтэйг нь сонгон авах

5. Хэрэв монголын төрөл хэлэнд нийцэх нэр байхгүй буюу байвч тохирохгүй ахул тэр юмны утга, чанарыг илэрхийлж чадахаар монгол нэр зориуд өгөх
6. **Газар ус, уул талын нэрийг** нутгийн ард түмний өгсөн, арай илүү тарж алдаршсан нэрээр нэрлэх, нэр хадмал толь бичиг, шинжлэх ухааны зургуудад европын нэрийг нэг зэрэг хэрэглэхээр⁶

хэлэлцэн тохирчээ. Одоогийн “газар усны нэр” хэмээсэн нэр томъёог тухайн үед “газар ус, уул талын нэр” гэж дэлгэрэнгүй байдлаар хэлж хэрэглэдэг байжээ. Эдүгээ энэхүү “уул тал”-ыг олноос тусгайлан онцгойлдоггүй болсон байна. Их эрдэмтэн Онходын Жамьян “Монгол хэл дээр шинэ шинэ ухааны нэр томъёо олж тогтсон нь ховорхон, газар орон бүр байтугай, хүн тус бүр өөр өөрийн дур зоргоор нэр томъёо өгөх нь олон тул монгол хэл бичгийн цэвэр оновчтойг нь бодож арваад ангийн⁷ комисс байгуулж, ухаан бүрийн нэр томъёо ба хэрхэн бичиглэх зэргийг оролдсоор иржээ. Судар бичгийн хүрээлэнгийн албаны монгол гишүүд цөөн тул гаднаас эрдэмтэн мэргэдийг нөхөр хань татаж, түмэн бодис, газар орны байдал зэргээс нэр томъёо олсоор ирэвч хүчин хүрч чадаагүй”⁸ явдлыг Улсын анхдугаар их хурлын индрээс шүүмжлэн хэлж байсныг дурдалтай.

Академич Б.Ринчен (1905-1977) доктор гярхай ажиглан тэмдэглэсэнчлэн “Хойд Солонгосын нийслэл хотын нэрийг орос үсэгт “Пхеньян” гэж бичдэг. Хойд Солонгосын нийслэлийн нэрийг хэрхэн бичихийг орос үсгийн дагуу “Пхеньян” гэж манай бичиг, хэвлэл мэтэд бичихэд, олон улсын хот зэрэг газар зүйн нэрийг хэрхэн зөв бичих журам зүйг шинжлэх ухааны үүднээс боловсруулан, бичлэгийг нь тогтоосон лавлах байхгүйн хараагаар, арга буюу, дорно дахины судлалгүй, хэлний шинжлэлийн мэргэжилгүй хүмүүс, бичих шаардлага гараад ирэхэд дэлхийн олон хэлний улс, хот зэргийн нэрийг орос хэлнээ хэрхэн бичихийг эрдэмтэн нь боловсруулсан орос зөв бичлэгийн зүйлийг баримтлахаас аргагүй бөгөөд монголоор яаж бичдэгийг тэр тухайд урд нь үзээгүй, кирил үсэгт бичих хэрэгцээ нь анх гарч байгаагаас хойш, орос үсгийн бичлэгийн зүйлийг дагалдахаас өөр аргагүй байсан байжээ. Монголынхоо пар пар, пир пир гэдгийг хэрхэвч пхар пхар, пхир пхир гэж бичихгүй. Монголынхоо па пэ-гийн дуудлагаар дуудвал, ёстой онох дүйхий нь мэдвэл, тэр хотын нэрийг “Пеньян” гэхэд яг л дуудлага нь таарах байжээ. “Тугалын пхүнз”, “гэрийн пхин” гэж бичихгүйгээс хойш, “Пхеньян”-ыг ч “Пеньян” гэж бичих нь монгол хэл бичигт зөв бичдэг, зөв дууддаг ёстой ягштал нийлэлцэх”⁹ байсан нь магад үнэн билээ. Энэ хотын нэрийг эдүгээ англи үсгээр “Pyong yang”, ханз үсгээр 平壤 хэмээн бичдэг. Өвөр монголд монгол бичгийн хэлээр rioekyeeit хэмээн бичдэг бол япон хэлээр ピョンヤン гэж тэмдэглэдэг. Үүнтэй холбогдуулж хэлэхэд, БНСУ-ын нийслэлийн нэрийг хэдэн арван жил “Сеул” хэмээн бичиж дуудаж байснаа хоёр орны харилцаа өргөжин дэлгэрэхийн үед буюу 1990-ээд оны эхнээс солонгос хэлний эх дуудлагад улам ойртуулан “Сөүл” гэж бичиж тэмдэглэх болсон билээ.

Энэчлэн “Hague [heig], Haiti [héiti], Hamburg [hæmbə:g], Hanoi [hánoi], Havana [həvænə] < испани: *abána, Hawaii [ha:wáii]” тэргүүтэн газар орны нэрийг орчин цагийн монгол хэлээр бичиж тэмдэглэхдээ угийн дуудлагын хэм хэмжээнд нь аль болох ойртуулан “Хаага, Хайти, Хамбург, Ханой, Хавана, Хавай” гэх мэтэчлэн нэгэн жигд байдлаар бичиж тэмдэглэж болох юм.

Профессор Ж.Сэржээ “Зарим оноосон нэрийн бичлэгийг нэг мөр болгох асуудалд” хэмээх өгүүлэлдээ монгол газар усны нэрийг олон хувилбартай бичиж тэмдэглэж байгаад ажиглалт хийж, доорх 4 зүйлд хуваан¹⁰ үзжээ. Үүнд:

⁶ Ч.Сэрээтэр, Х.Цэрэв, Б.Чадраа. Монгол улсын Шинжлэх ухааны академийн түүх. -Улаанбаатар., 2002. х.28

⁷ Энэхүү “ангийн” гэдэг үг нь эдүгээгийн “салбар” хэмээх үгтэй утга дүйнэ.

⁸ БНМАУ-ын анхдугаар их хурал (дэлгэрэнгүй тайлан). -Улаанбаатар., 1984. х.126

⁹ Б.Ринчен. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган, VI боть (“Монгол бичгийн хэлний зүй”, дэд дэвтэр, авиан зүй) [эмхэтгэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав] (хэвлэлд бэлтгэсэн Ж.Ганбаатар). -Улаанбаатар., 2012. х.95

¹⁰ Ж.Сэржээ. Монгол хэлний нэр зүй, утга зүйн судалгааны зарим асуудал (редактор Э.Пүрэвжав). -Улаанбаатар., 2014. х.41

Нэгдүгээрт, монгол нутгийн аялгууны нөлөөгөөр авиа сэлгэн хэлэгддэг нэрсийг бичихдээ нэг мөр болголгүй, өөр өөрөөр бичсэн нь элбэг тохиолддог. Жишээ нь: Хотилын *худаг*, *Готилын худаг* (Өмнөговь, Булган сум), *Гацуурт гол*, *Гачуурт гол* (Сэлэнгэ, Зүүнхараа сум), *Тором уул*, *Дором уул* (Хөвсгөл, Цэцэрлэг сум) гэх мэтээр гийгүүлэгч авиаг сэлгүүлэн сольж бичсэнээс өөр өөр нэр болсон.

Хоёрдугаарт, монгол хэлний эгшиг авиаг сэлгүүлэн бичсэнээс нэгэн газрын нэр болж чадахгүйд хүрсэн тал байна. Тухайлбал: *Билчирийн хөндий*, *Бэлчэрийн хөндий* (Булган, Гурванбулаг сум), *Бөхөг гол*, *Бүхэг гол* (Төв, Алтанбулаг сум), *Үлийн даваа*, *Өлийн даваа* (Төв, Заамар сум).

Гуравдугаарт, эгшиг, гийгүүлэгч авиаг сэлгүүлэн өөр өөрөөр хэлдгийг нь дагуулан бичихээс гадна, нэг нэрийг бүр өөр нэр болгон бичсэн нь цөөнгүй байна. Жишээлбэл: *Ихэр уул*, *Цэхэр уул* (Увс, Малчин сум), *Ёлт уул*, *Жолт уул* (Баян-Өлгий, Алтай сум), *Шавар*, *Явар* (Ховд, Манхан сум), *Хустай ухаа*, *Хулстай ухаа* (Дорнод, Сүмбэр сум).

Дөрөвдүгээрт, газрын оноосон нэрийг тийн ялгалын нөхцөлтэй, нөхцөлгүй бичсэнээс хоёр өөр нэр шиг болжээ. Жишээ нь: *Аргалант уул*, *Аргалантын уул* (Ховд, Чандмань сум), *Аршаан ухаа*, *Аршааны ухаа* (Хэнтий, Дэлгэрхаан сум), *Баян тал*, *Баянгийн тал* (Дорнод, Сүмбэр сум).

Академиц Ц.Дамдинсүрэн (1908-1986) профессор 1983 онд нийтлүүлсэн “Монгол үсгийн дүрмийн толь” бичгийнхээ хавсралт болгон хэвлүүлсэн “Монгол үсгийн дүрэм”-ийн 28 дугаар зүйлийн “гээгдэх эгшиг”-ийн тухай хэсэгт:

“Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшигийг гээхгүй. Жишээлбэл: *Матад - Матадаас*, *Орхон - Орхоны* гэх мэт”¹¹ хэмээжээ. “Монгол үсгийн дүрэм”-ийн 47 дугаар зүйлийн “том үсгээр бичих” хэсгийн хоёрдугаарт:

“Хүний нэр, амьтан, хот суурин, уул ус зэрэг **ертөнц дээр ижилгүй юмны нэрийг** том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: *Улаанбаатар хот*, *Богд уул*, *Орхон гол* гэх мэт”¹²

“Монгол үсгийн дүрэм”-ийн 47 дугаар зүйлийн “том үсгээр бичих” хэсгийн наймдугаарт:

“Хамт бичиж заншсан хоёр үгнээс бүтсэн оноосон нэрийн хоёрдугаар үг нь эгшгээр эхэлсэн байвал хооронд нь холбоос тавьж, хоёр дахь үгийг томоор эхэлж бичнэ. Жишээлбэл: *Баян-Өлгий*, *Баруун-Урт хот* гэх мэт”¹³ хэмээн тэмдэглэснээс ондоо газар усны нэрийг жигдлэн бичих талаарх албан ёсны баримт бичиг Монгол улсад өнөө хүртэл бараг үгүй байна.

Монгол газар усны нэрийг зөв тэмдэглэх, зөв бичих хоёр нь түүхэн үнэнийг мадаггүй зөвөөр илэрхийлэхэд туйлын чухал ач холбогдолтой юм. “Зөв тэмдэглэх” гэдэгт нэг газрын нэрийг янз бүрээр хэлж бичдэгийг нэгэн жигд болговол зохино гэсэн санааг агуулж байгаа болно. Тухайлбал, Ховд аймгийн төвийн нэрийг “Ховд хот”, “Жаргалант хот” хэмээн хоёр хувилбараар бичиж хэлэх нь олонтоо байгааг нэгэн жигд болговол зохино. Мөн “зөв бичих” гэдгээр орчин цагийн монгол хэлний тэмдэглэгээний хувьд “*Гацуурт гол*, *Гачуурт гол*”, “*Билчирийн хөндий*, *Бэлчэрийн хөндий*”, “*Ёлт уул*, *Жолт уул*”, “*Баян тал*, *Баянгийн тал*” гэхчлэн ялгаа зөрүүтэй бичиж байгааг жигдэлбэл зохино гэсэн санааг илэрхийлсэн болно.

Даяарчлалын эрин үед бидний боловсруулан хийвэл зохих ажлын нэг бол монгол хэлний оноосон нэрийн болзмол латин (ромжин) үсгийн цагаан толгой гэж үзэж байна. Монгол газрынхаа уул ус, хот суурин тэргүүтний нэрийг европын улсуудын бичиг зохиол, газрын зураг сэлтэд зөв зүйтэй бичүүлэх талаар бид төдий л санаа тавиагүй явж ирсний харгайгаар манай газар усны нэрийг европ зүг рүү янз янзаар бичиж, эцэстээ чухам аль нь зөв болохыг тэр газрын хүн ялгаж цэгцлэх нь байтугай, эргээд монгол хүнд ч танигдах аргагүй хачин

¹¹ Ц.Дамдинсүрэн, Б.Осор. Монгол үсгийн дүрмийн толь (редактор С.Мөөмөө). -Улаанбаатар., 1983. х.413

¹² Ц.Дамдинсүрэн, Б.Осор. Монгол үсгийн дүрмийн толь (редактор С.Мөөмөө). -Улаанбаатар., 1983. х.419

¹³ Ц.Дамдинсүрэн, Б.Осор. Монгол үсгийн дүрмийн толь (редактор С.Мөөмөө). -Улаанбаатар., 1983. х.421

нэр буй болж байгааг¹⁴ судлаач Ч.Догсүрэн (1934-2002) гуай 1979 онд сэрэмжлүүлэн бичиж байсныг дурдахад илүүдэх юун.

Монгол оноосон нэрийн үндсэн гол хоёр багана бол монгол газар усны нэр, монгол хүний нэр хоёр болдог. Монгол хүний нэр нь Улсын бүртгэл мэдээллийн төв гэсэн нэгдсэн сүлжээ бүхий эзэнтэй байдаг бол монгол газар усны нэрэнд улсын хэмжээний тодорхой харьяалал эзэн бараг л алга байна гэхэд хилсдэхгүй болов уу.

Монгол газрын нэр судлалаар олон тооны чамбай бүтээл бичиж туурвисан эрдэмтэн судлаач Чимидийн Догсүрэн (1934-2002) мэндэлсний 80 жил, Осорнамжимын Сүхбаатар (1944-2005) мэндэлсний 70 жил нь “Монголчууд ба газрын зураг” (монголын газрын зураг, газрын нэрийн түүх, соёлын судалгаа) сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг хийж буй энэхүү 2014 онд тохиож байгааг тэмдэглэн хэлэхэд нэн таатай байна.

АШИГЛАСАН ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- БНМАУ-ын анхдугаар их хурал (дэлгэрэнгүй тайлан). -Улаанбаатар., 1984. 368 х
- Дамдинсүрэн Ц, Осор Б. Монгол үсгийн дүрмийн толь (редактор С.Мөөмөө). -Улаанбаатар., 1983. 431 х
- Догсүрэн Ч. Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол латин цагаан толгой. –“Э. Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлал”, IX боть. -Улаанбаатар., 2006. х.82-90
- Жамьян О. Анхан сурах хөвгүүдийн оюуныг нээх Тодорхой толь хэмээгдэх оршив. –“Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг”. -Хөххот., 1959. х.167-177
- Лувсандэндэв А. Газар зүйн оноосон нэр бичих дүрэм. –“А.Лувсандэндэв. Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь”. -Улаанбаатар., 2002. х.324-326
- Монгол хэлний үгийн сан судлал (“Монгол улсын Шинжлэх ухаан” хэмээх 108 боть цувралын XII боть). -Улаанбаатар., 2009. 186 х
- Пүрэвжав Э. Монгол хэл бичгийн судлалд О.Жамьян гүнгийн оруулсан хувь нэмэр. –“Монгол хэл шинжлэл”, IX (XXXI) боть, III дэвтэр. -Улаанбаатар., 2006. х.26-36
- Ринчен Б. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган, VI боть (“Монгол бичгийн хэлний зүй”, дэд дэвтэр, авиан зүй) [эмхэтгэн хэвлүүлсэн Э.Пүрэвжав] (хэвлэлд бэлтгэсэн Ж.Ганбаатар). -Улаанбаатар., 2012. 348 х
- Сүхбаатар О. Монголын газар усны нэрийн домог (Mongolian Legends of the Land) [редактор Х.Сампилдэндэв]. -Улаанбаатар., 2001. 278 х
- Сэржээ Ж. Монгол хэлний нэр зүй, утга зүйн судалгааны зарим асуудал (редактор Э.Пүрэвжав). -Улаанбаатар., 2014. 208 х
- Сэрээтэр Ч., Цэрэв Х., Чадраа Б. Монгол улсын Шинжлэх ухааны академийн түүх. -Улаанбаатар., 2002. 285 х

¹⁴ Ч.Догсүрэн. Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол латин цагаан толгой. –“Э.Пүрэвжав. Монгол хэл бичгийн судлал”, IX боть. -Улаанбаатар., 2006. х.83

SUMMURY

Proper names of a language are the significant component of the language vocabulary. Place names, a part of proper names, are a phenomenon which is deliberately connected with ancient historic traditions, rites and human lifestyles. Sure enough, place names have been used for over thousands of years.

Studying the origin of place names is connected with many fields of sciences as history, linguistics, philology, culture, traditions, customs, religions and geography. In addition, we should spell the names of places properly. The concept of “The Spelling of Mongolian Place Names Correctly” has a broad meaning, if it is generally considered, it means spelling or writing all names of places of the world correctly in the Mongolian language, or if it is narrowly considered, it means spelling or writing the names of Mongolian places correctly.

The problem of spelling the proper names of Mongolian geography is a hard work that requires not only the geographic knowledge, but also the linguistic knowledge. When geographic proper names are spelt, the spelling and pronunciation of contemporary Mongolian language should be adhered. We are accustomed to spelling Mongolian proper names by the rule of compounding.

Spelling and recording of Mongolian place names correctly is significant for determining the historic truth without any errors and mistakes. “Recording correctly” means that we should systemize the occurrence that we spell and record the same place by the use of different names. For instance, the center of Khovd province is spelt and pronounced as “Khovd city” or “Jargalant city”. Furthermore, “spelling or writing correctly” means we should arrange the different spelling occurrences of some names for example: “*Гацуурт гол, Гачуурт гол*”, “*Билчирийн хөндий, Бэлчэрийн хөндий*”, “*Ёлт уул, Жолт уул*”, “*Баян тал, Баянгийн тал*” which are in the contemporary Mongolian language.

At the globalization era, one of the most urgent works that we should do is arranging the usage of the Latin letter, applied for Mongolian proper names.